МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТ

2014.04.22 № 04/32 ҮАГ-САГ/2014/201-СТПА-ПТЗ

Зөрчил арилгуулах тухай

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн зарлагыг түүвэрлэн үзэхэд: ЗТЯ-ны 5 ажилтанд томилолтын зардалд 39.1 сая төгрөгийг олгосон , Сэргээн засал, сувилал цогцолборын ажилчдад үр дүнгийн шагнал цалинг олгохдоо 2013 оны сүүлийн хагас жилээс хойш ажилд орсон ажилтнуудад 18.3 сая төгрөгийг олгосон ба нийт 57.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмын 1.8.2,1.8.4–д ажилтныг гүйцэтгэсэн ажлын чанар,үр дүн, байгууллагад оруулсан хувь нэмрийг үнэлэн шагнаж урамшуулна гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

"Төрийн аудитын тухай" хуулийн 15.1.12-д: ".....аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, Монгол улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д:"....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

Дээрх зөрчлийг арилгаж, биелэлтийг 2014 оны 7 дугаар 25-ны дотор ҮАГ-т ирүүлэхийг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Т.Лхагвасүрэн, Ерөнхий нягтлан бодогч М.Энхмаа нарт хариуцуулав.

АУДИТОР Ш.ОТГОНБАЯР

С.БАТ-ЭРДЭНЭ

УХА0122

1. Зэвсэгт хүчний 016, 119, 338 дугаар ангиудын 2013 оны санхүүгийн тайланг аймаг, орон нутгийн Аудитын газруудаар аудит хийлгээгүй холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох, Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2014 оны санхүүгийн тайланг аудитад бүрэн хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Төрийн нарийн бичгийн дарга З.Болдбаатар, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Х.Батсүх нарт даалгав.

Энэхүү албан шаардлагын биелэлтийг 2014 оны 6 дугаар сарын 25-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэхийг мэдэгдье.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР Г.ЮРА

УХА0122

Үндэсний аудитын газрын
2014 оны 4 дүгээр сарын
22 өдрийн 04/32 тоот
актын хавсралт №1

УХА0122

ИНЕГ-аас томилолт авсан ЗТЯ-ны ажилтнууд

| № | Ажилтнуудын нэрс | Томилолтоор ажилласан улс | Томилолтын нийт зардал |
|---|---|---|---|
| 1 | Б.Батзаяа, П.Пүрэвсүх, Ч.Мөнхтуяа | Хонг Конг | 3,988.468 |
| 2 | Б.Батзаяа, Ч.Мөнхтуяа, Э.Энхтуяа | Япон | 9,323.495 |
| 3 | Б.Батзаяа, Ч.Мөнхтуяа, Б.Нямдаваа | ӨАБНУ | 25,779.133 |
| | Дүн | | **39,091.097** |

Сэргээн засал, сувилал цогцолборын 2013 оны сүүлийн хагас жилээс хойш ажилд орсон ажилчдад олгосон үр дүнгийн шагнал.

| 1 | Нэр | Албан тушаал | Ажилд орсон он сар | Олгосон урамшуулал |
|---|---|---|---|---|
| 2 | н.Батцэцэг | Захирал | 2013.06 сар | 2,500.000 |
| 3 | н.Моломжамц | Үйлчилгээний мэргэжилтэн | 2013.07 сар | 2,500.000 |
| 4 | н.Батгэрэл | Ахлах-нягтлан бодогч | 2013.07 сар | 1,000.000 |
| 5 | н.Гэрэлмаа | Захиргаа хүний нөөцийн ерөнхий менежер | 2013.09 сар | 2,000.000 |
| 6 | н.Батаа | Тооцооны нягтлан бодогч | 2013.11 сар | 2,000.000 |
| 7 | н.Лхагвадулам | Ахлах тогооч | 2013.08 сар | 2,500.000 |
| 8 | н.Наранхүү | Тогооч | 2013.07 сар | 1,000.000 |
| 9 | н.Төрмөнх | зөөгч | 2013.09 сар | 1,200.000 |
| 10 | н.Золзаяа | Зохион байгуулагч-хүлээн авагч | 2013.08 сар | 1,200.000 |
| 11 | Т.Оюунсүрэн | Цэвэрлэгч-үйлчлэгч | 2013.10 сар | 1,200.000 |
| 12 | н.Сарантуяа | сувилагч | 2013.10 сар | 1,200.000 |
| | Дүн | | | **18,300.000** |